

## Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах тухай зар

[Админ](#) 2024-10-09

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

### Тавигдах болзол, шаардлага:

- төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

### Бүрдүүлэх материал:

- Хүсэлт
- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/
- Цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэний хувьд цэргийн үүрэгтний үнэмлэх
- Сахилгын шийтгэлтэй эсэх тодорхойлолт
- Төрийн албан хаагчийн ерөнхий болон тусгай шалгалт өгсөн нотлох баримтыг хавсаргах.

### Материал хүлээн авах:

- Хугацаа: 2024 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 17.00 цаг хүртэл
- Нийгмийн даатгалын газар: orhon@ndaatgal.mn Холбоо барих утас: 99262089

## ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛД ШИЛЖҮҮЛЭН АВАХ АЖЛЫН БАЙРНЫ ЖАГСААЛТ

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаал	Сул орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод			
					Төрөл	Ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
<b>УДИРДАХ АЛБАН ТУШААЛ /БҮТЦИЙН НЭГЖИЙН УДИРДАХ /</b>										
3	Хотын захирагчийн алба		Төсөвчин	1	Гүйцэтгэх	T3-8	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	Барилгын инженер, замын инженер, цахилгааны инженер, дулааны инженер, иргэний болон <u>үйлдвэрлэлийн</u> барилга	богино болон дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх" гэснийг хассугай.  <i>Энэ хэсэгт Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 267 дугаар тогтоол, 2023 оны 90 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/</i>	Дэс түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил эхсүл төрийн жинхэнэ албанд 2-оос доошгүй жил ажилласан байх.
4	Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар	Захиргаа, хяналтын хэлтэс	Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	1	гүйцэтгэх	T3-9	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	-Эрх зүй /0421/ -багш, мэргэжлийн /0114/ -Эдийн засаг /0311/ -социологи болон соёл судлал /0314/ -сэтгүүл зүй /0321/ -нягтлан бодох бүртгэл, татвар /0411/ -санхүү, банк, даатгал /0412/ -менежмент ба удирдахуй /0413/ -маркетинг, зар сурталчилгаа /0414/ -математик /0541/ -өгөгдлийн сан, сүлжээний загварчлал/дизайн/ ба удирдлага /0612/ -програми хангамж, түүний хэрэглээ хөгжүүлэлт ба шинжилгээ /0613/		Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.

